

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БОЛОВСРОЛ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 03 дугаар
сарын 07 өдөр

Дугаар А/74/1.../099

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах нь” үндэсний зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх, хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр, үндэсний зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд сөрөг нөлөө үзүүлж байгаа шалтгааныг тогтоох, ерөнхий боловсролын сургуульд хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах орчин бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газар /Д.Эрдэнэчимэг/-т, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Б.Үүлэнсолонго/-т тус тус үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал /Л.Насанцэнгэл/-д, Боловсролын хүрээлэнгийн захирал /М.Итгэл/-д, төлөвлөгөөг эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Эрүүл мэндийн яамны болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны санхүү, төсвийн асуудал хариуцсан газар, хэлтэст, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамдын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.





Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 02 сарын 07-ны өдрийн ДТМ/1..... дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|----------------------|--|
| Дарга: | - Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; |
| Дэд дарга: | - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга; |
| Нарийн бичгийн дарга | - Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа хариуцсан дэд захирал; |
| Гишүүд | - Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга;
- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал;
- Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхэд, өсвөр үеийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын суурь, бүрэн дунд боловсролын стандарт, хөтөлбөр, арга зүйн бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын Суралцагчийн хөгжил төлөвшил, хамгааллын бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн; |

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газрын сургуулийн өмнөх боловсролын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн;
- Боловсролын хүрээлэнгийн Секторын эрхлэгч, Биологийн сургалтын хөтөлбөрийн судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан;
- Эрүүл мэндийн яамны харьяа Эх, хүүхдийн, эрүүл мэндийн үндэсний төвийн хүүхэд, өсвөр үеийн эмч;
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн ахлах багш;
- Монгол Улсын Боловсролын их сургуулийн Тусгай боловсролын тэнхимийн эрхлэгч;
- Цагдаагийн ерөнхий газрын Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн дарга;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Радио, телевиз, нийгмийн мэдээллийн сүлжээний бодлогын хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хуулийн хэлтсийн дарга;
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын сэтгэц, хавдрын асуудал хариуцсан мэргэжилтэн;
- НҮБ-ын Хүүхдийн сангийн Өсвөр үе, ХДХВ/ДОХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/;
- Монгол дахь Хүүхдийг ивээх сангийн Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал, хөтөлбөрүүдийн менежер /зөвшилцсөнөөр/;
- “Сэтгэл судлалын хүрээлэн” төрийн бус байгууллагын тэргүүн /зөвшилцсөнөөр/;
- “Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг” төрийн бус байгууллагын тэргүүн /зөвшилцсөнөөр/.

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 03 сарын 07-ны өдрийн АТ/21/..... дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт



“Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах нь” зөвлөгөөний Зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Төлөвлөсөн ажил	Хугацаа	Хамтран ажиллах байгууллага	Хариуцах байгууллага	Хүрэх үр дүн
1	Нэг. Хүүхэд өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар:				
1.1	Өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн судалгааг 5 жил тутам эрүүл мэнд, боловсрол, гэр бүл хүүхэд хөгжил хамгааллын салбарыг оролцуулан хамтран тогтмол хийдэг болох орчин бүрдүүлэх	2018 - 2021	Аймаг дүүргийн ЭМГ, БСУГ	ЭМЯ, СЭМҮТ, БСШУСЯ	Эрсдэлт хүчин зүйлийн тархалтын суурь судалгааны дүнтэй болно.
1.2	Сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын архи, тамхи, мансууруулах бодисын (Assist) хэрэглээний түвшинг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээлэл технологийн багштай хамтрах, судалгаанд оролцогч, бодлого боловсруулагчдад мэдээлэл шууд ашиглагдах програм боловсруулах	2018-2020	Аймаг дүүргийн ЭМГ, БСУГ	ЭМЯ, СЭМҮТ, БСШУСЯ, НҮБХС, НЭМҮТ	Бодитой шийдвэр, зөвлөмж гарах боломж бүрдэнэ.
1.3	Сэтгэцийн эрүүл мэнд, түүнд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн судалгааны мэдээллийн салбар дундын нэгдсэн цахим сан бүрдүүлж, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд байршуулах	2018-2020	Аймаг дүүргийн ЭМГ, БСУГ, НЭМТ	ЭМЯ, СЭМҮТ, БСШУСЯ	Салбар дундын удирдлага мэдээллийн сан бүрдэж, ажлын уялдаа сайжирна.
1.4	Аймаг, нийслэлийн Нийгмийн эрүүл мэндийн төвд өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч, ЕБС-д ЕБС-ийн сургуулийн эмч болон сэтгэл зүйч, нийгмийн ажилтны баг бүрдүүлж,	2018-2020	ГБХЗХГ, Аймаг нийслэлийн ЭМГ, БСУГ	БСШУСЯ ЭМЯ, СЭМҮТ,	Хийх ажлын чиглэл тодорхой болж, давхардал, хийдэгдэл

	ажиллуулах, ХГБХТ-ийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх 3 салбарын хамтарсан журам боловсруулж, батлуулах				арилна.
1.5	Сургуулийн хүрээнд "Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих баг" бий болгох, ажиллах журмыг батлуулах	2018-2020	Аймаг, нийслэлийн ЭМГ, БСУГ, СНАН	БСШУСЯ, ЭМЯ, ХНХЯ, СЭМҮТ	Урьдчилан сэргийлэх ажил сайжрах боломж бүрдэнэ.
1.6	ЕБС-ийн Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөр, агуулгад сэтгэцийн эрүүл мэндийн мэдлэгийг олгох сургалтыг тусгах	2018-2020	НЭМҮТ СЭМҮТ Аймаг, нийслэлийн БСУГ, БМДИ	БСШУСЯ ЭМЯ,	Өсвөр үеийнхний мэдлэг, хандлага сайжрах нөхцөл бүрдэнэ.
1.7	Сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвартсэтгэцийн эрүүл мэндийг эрт илрүүлэх, зөвлөгөө өгөх асуудлыг тусгах, тус үйлчилгээг үзүүлэх сургуулийн эмчийн чадавхийг бэхжүүлэх	2018-2020	НЭМҮТ СЭМҮТ	ЭМЯ, БСШУСЯ	Эмчийн мэдлэг, ур чадвар сайжирна.
1.8	ЕБС-ийн удирдлага, багш, нийгмийн ажилтны сэтгэцийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг сайжруулах асуудлыг багш нарын мэргэжил дээшлүүлэх институтийн сургалтын хөтөлбөрт оруулах	2018-2020	СЭМҮТ Аймаг, нийслэлийн БСУГ	БСШУСЯ, ЭМЯ	Мэдлэг, хандлага сайжирна.
1.9	ЕБС-ийн сурагчдын эрүүл мэндийн үзүүлэлтэд сэтгэцийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт (сэтгэлээр унадаг, гутардаг сурагчдын тоо, амиа хорлосон сурагчдын тоо, амиа хорлох бодолтой сурагчдын тоо, архи хэтрүүлэн хэрэглэдэг сурагчдын тоо, тамхи татдаг сурагчдын тоо, мансууруулах бодис хэрэглэж үзсэн сурагчдын тоо, дэлгэцийн хамааралтай сурагчдын тоо, худлаа ярьдаг хүүхдийн тоо, хулгай хийдэг сурагчдын тоо, гэрээсээ зугтдаг, зайлсхийдэг сурагчдын тоо, сурлагын дүн	2018-2020	СЭМҮТ НЭМҮТ ЭМХТ Аймаг, нийслэлийн БСУГ, ЭМГ	ЭМЯ, БСШУСЯ	Шийдвэр гаргах нотолгоо, мэдээлэлтэй болно.

	буурсан сурагчдын тоо, анхаарал нь төвлөрдөггүй сурагчдын тоо, хэтэрхий хөдөлгөөнтэй байдаг сурагчдын тоо), бүртгэх, мэдээлэх, нэгтгэх журам боловсруулах				
1.10	"Сэтгэцийн тулгамдсан асуудлын шийдэл" сэдэвт онлайн шинэ арга зам нэвтрүүлэх	2018-2020	Аймаг нийслэлийн ЭМГ	СЭМҮТ, НҮБХС	Тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирна.
1.11	Онлайн сургалтын хичээл, зөвлөгөө, гарын авлага боловсруулах	2018-2020	Аймаг нийслэлийн ЭМГ	БСШУЯ, НҮБХС, СЭМҮТ,	Тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирна.
1.12	Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр инфографик, анимейшн боловсруулах, түгээх, хэрэгжүүлэх	2018-2020	Аймаг нийслэлийн ЭМГ СЭМҮТ	НЭМҮТ, НҮБХС	Тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирна.
1.13	Хэвлэл мэдээллийн ажилтан, сэтгүүлч нартай хамтарсан уулзалт зохион байгуулж, хэвлэл мэдээллийг ашиглан хүүхэд, өсвөр үеийнхэнд нөлөөллийн арга хэмжээ явуулах	2018-2020	Аймаг нийслэлийн ЭМГ, БСУГ	ЭМЯ, СЭМҮТ, БСШУСЯ, НҮБХС, Мэдээлэл ХХТ газар	Тусламж, үйлчилгээний төрөл, хүртээмж сайжирна.
1.14	Компьютер тоглоомын газрын ажиллах хуваарь, эрүүл ахуйн орчны стандарт, зохимжгүй агуулгатай цахим тоглоомзэрэг хүүхдийн сэтгэхүйд сөрөг нөлөө үзүүлж байгаа асуудлыг жилд 2 удаа шалгаж, сайжруулах арга хэмжээ авах	2018-2021	Аймаг нийслэлийн МХГ, ЦГ,	МХЕГ,ЦЕГ,М ХХТГ	Сэтгэцийн эрүүл мэндийн эрсдлийг бууруулна.
Хоёр. Хүүхэд, өсвөр үеийн боловсрол, тэдний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр					
2.1	Хүүхэд өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр "Үе тэнгийн сургагч", сайн дурын клуб ажиллуулах	2018-2020	НҮБХС,	СЭМҮТ, Аймаг болон Нийслэлийн ЭМГ, БСУГ, НЭМҮТ	Тусламж, үйлчилгээний төрөл, хүртээмж сайжирна.
2.2	Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн зөв төлөвшилтийг урлагийн боловсролоор дамжуулан төлөвшүүлэх арга хэмжээ зохион байгуулах	2018-2020	Аймаг, нийслэлийн БСУГ	БСШУСЯ	Тусламж, үйлчилгээний төрөл, хүртээмж сайжирна.
2.3	Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийн эрсдэлийг тодорхойлж, эрсдэлтэй хүүхэдтэй ажиллах эцэг эх,	2018-2020	НҮБХС,ТББ ЦЕГ,	СЭМҮТ	Мэдлэг хандлага сайжирна. орчин бүрдэнэ.

	гэр бүлд зориулсан гарын авлага боловсруулах				
Гурав. Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх чиглэлээр					
3.1	Өсвөр үеийн эмчийн мэргэшүүлэх сургалтын агуулгад сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын талаарх агуулгыг тусгах, оношилгоо, эмчилгээний удирдамж боловсруулах	2018-2020	Аймаг дүүргийн ЭМГ	ЭМЯ, СЭМҮТ, ЭХЭМҮТ	Тусламж, үйлчилгээний чанар сайжирна
3.2	Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, зөвлөгөө өгөх сургалтыг Өсвөр үеийн эмч нарт зохион явуулах	2018-2020	Аймаг дүүргийн ЭМГ	ЭМЯ, СЭМҮТ, НҮБХС	Мэдлэг хандлага сайжрах орчин бүрдэнэ.
3.3	Аймаг, дүүргийн ЗД, ЭМГ-ын дарга, Нэгдсэн эмнэлгийн дарга нарын үр дүнгийн гэрээнд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих асуудлаар тодорхой ажил, шалгуур үзүүлэлт оруулсан байх	2018-2020	СЭМҮТ, аймаг дүүргийн ЭМГ, БГ	ЭМЯ, БСШУСЯ	Шийдвэр гаргагчдын оролцоо сайжирна.
3.4	Сэтгэцийн эрүүл мэндийн талаар хэвлэл мэдээллийнхэн, сайт ажиллуулдаг байгууллагад тогтмол мэдээлэл өгдөг сүлжээ бий болгох	2018-2020	Аймаг дүүргийн ЭМГ,	ЭМЯ, СЭМҮТ, НЭМҮТ, ЭХЭМҮТ	Тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирна.
3.5	Хүүхдийн болон ӨЭМТ-ийн эмч нарт өсвөр үеийн сэтгэл зүйн онцлог, харилцааны асуудлаар сургалт явуулах, гарын авлага гаргах	2018-2020	Аймаг дүүргийн ЭМГ	ЭМЯ, СЭМҮТ, НҮБХС	Мэдлэг хандлага сайжрах орчин бүрдэнэ.

-оОо-